




“ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ”

2014 оны 9-р сарын статистикийн танилцуулга



Улаанбаатар хот
2014 он

АГУУЛГА

Хуудасны
дугаар

	ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2012-2014 ОН	3
	ДҮҮРГИЙН ТӨСӨВ	4
	АЖ ҮЙЛДВЭР	6
	ХҮНСНИЙ БАРААНЫ ҮНЭ	9
	ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	10
	ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	11
	ГЭМТ ХЭРЭГ	13
	ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ	15

“Хан-Уул дүүргийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн танилцуулга
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жил бүрийн эхний 9 сарын байдлаар


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012 он	2013 он	2014 он
Суурин хүн ам, сарын эцэст	хүн	128212	129562	133552
Шинээр төрсөн хүүхэд	тоо	2531	2488	2653
Ажилгүйчүүд , сарын эцэст	хүн	689	524	1159
Үүнээс: эмэгтэй	хүн	374	325	623
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	1540	931	952
Дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	868	837	976
Дүүргийн төсвийн орлого	сая.төгрөг	12474.1	13147.7	15024.7
Дүүргийн төсвийн зарлага	сая.төгрөг	13102.4	26243.6	27532.1



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн орлого 2014 оны эхний 9 сард 15024.7 сая төгрөг болж, орлогын төлөвлөгөө төлөвлөснөөс 407.6 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар дутуу бүрдсэн байна.

Зураг 1. Орон нутгийн төсвийн гүйцэтгэл, жилийн бүрийн эхний 9 сарын байдлаар сая.төг



Хүн амын орлогын албан татвар төлөвлөснөөс 32.1 хувь буюу 1527.8 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Үүнд: үйл ажиллагааны орлого 33.3 хувь, орлогыг тодорхойлох боломжгүй иргэний татвар 6.0 хувиар биелсэн байна.

Бусад татвар хураамж 27.1 хувиар дутуу бүрджээ.

Хүснэгт 1. Дүүргийн төсөв 2014 оны 9 сарын байдлаар, сая.төг

	Төлөвлөсөн	Гүйцэтгэсэн	ТБ %	Зөрүү
Төсвийн орлогын дүн	15432.3	15024.7	97.4	-407.6
1. Татварын орлогын дүн	14002.7	13029.0	93.0	-973.7
1.1 Орлогын албан татвар	4757.9	6285.7	132.1	1527.8
Хүн амын орлогын албан татвар	4757.9	6285.7	132.1	1527.8
Үйл ажиллагааны орлогын	4394.2	5858.6	133.3	1464.4
Хөрөнгө борлуулсны орлогын	325.2	386.3	118.8	61.1
Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний татвар	38.5	40.8	106.0	2.3
1.2 Өмчийн татвар	3.8	4.2	110.5	0.4
Бууны албан татвар	3.8	4.2	110.5	0.4
1.3 Бусад татвар (төлбөр, хураамж)	9241.0	6739.1	72.9	-2501.9
Улсын тэмдэгтийн хураамж	8261.2	6083.0	73.6	-2178.2
Байгалийн нөөц ашигласны төлбөр	7.2	11.9	165.3	4.7
Усны төлбөр	7.2	11.9	165.3	4.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	69	43.3	62.8	-25.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	903.6	600.9	66.5	-302.7
2. Татварын бус орлого	1429.6	1995.7	139.6	566.1
Хүү, торгуулийн орлого	1192.7	1850.4	155.1	657.7
Бусад орлого	32.9	43.3	131.6	10.4
Төсөвт байгууллагын өөрийн орлого	204	102	50.0	-102


Хүснэгт 2. Орон нутгийн төсвийн орлого, сая төг

	Төсвийн орлого			Үүнээс:					
	Бүгд	ТБ %	Зөрүү	Татварын орлого			Татварын бус орлого		
				Бүгд	ТБ %	Зөрүү	Бүгд	ТБ %	Зөрүү
Дүн	15024.7	97.4	-407.6	13029	93	-973.7	1995.7	139.6	566.1


Дүүргийн төсвийн орлого 2014 оны эхний 9 сард 15024.7 сая төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.3 хувиар өссөн байна.

Орон нутгийн төсвийн зарлага 27532.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 20.5 хувиар буюу 7117.5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулжээ. Нийт зарлагын 43.9 хувийг цалин хөлс, 4.8 хувийг нийгмийн даатгалын шимтгэл, 10.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 41 хувийг татаас ба бусад зардалд тус тус зарцуулсан байна.

Зураг 2. Төсвийн орлого, 2014 оны эхний 9 сарын байдлаар



Зураг 3. Төсвийн зарлага, жил бүрийн эхний 9 сарын байдлаар






АЖ ҮЙЛДВЭР


Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2014 оны эхний 9 сард 425.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 508.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад үйлдвэрлэлт 12.8 хувиар, борлуулалт 18.9 хувиар тус тус өссөн байна.

Зураг 4. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, борлуулалт, 2013-2014 оны сар бүрээр, тэрбум төгрөг




Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 448.1 тэрбум төгрөгийг дотоодод, 60.3 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 11.8 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 71.7 хувийг ноос, ноолуур, нэхмэлийн үйлдвэрлэлт, 7.2 хувийг арьс ширний үйлдвэрлэлт, 1.0 хувийг архи үйлдвэрлэлт, 0.4 хувийг хүнсний бусад үйлдвэрлэлт, 16.6 хувийг төмрийн хүдэр олборлолт, 3.7 хувийг бусад ашигт малтмалын олборлолт тус тус эзэлж байна.

Зураг 5. Үйлдвэрлэлт, тэрбум төг



Зураг 6. Борлуулалт, 2012-2014 он, тэрбум төг



Хүснэгт 3. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/


Салбараар	Нийт бүтээгдэхүүн		
	2013 он I-IX сар	2014 он I-IX сар	$\frac{2014}{2013} \%$
Уул уурхай олборлох үйлдвэр	13227.3	13453.3	101.7
Төмрийн хүдэр олборлолт	13227.3	10085.1	76.2
Бусад ашигт малтмал олборлолт	-	3368.2	-
Боловсруулах үйлдвэр	322341.7	352274.8	109.3
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	170823.7	189666.4	111.0
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	429.8	732.9	170.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7306.7	10740	147.0
Хүнсний бусад бүтээгдэхүүн	4977.2	16674.8	3.3*
талх, нарийн боов үйлдвэрлэл	11304.5	10925.6	96.6
архи үйлдвэрлэл	49091.3	45715.8	93.1
пиво үйлдвэрлэл	48216.5	51283.4	106.4
Ундаа үйлдвэрлэл	49497.7	53593.9	108.3
Нэхмэлийн үйлдвэрлэлт	88425.1	106226.2	120.1
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	20.4	597.2	29.2*
Арьс шир боловсруулах үйлдвэр	2775.5	7451.7	2.7*
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	392.6	465.6	118.6
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	3178.3	3407.1	107.2
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	30746	22159.6	72.1
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	10345.8	13863	134.0
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	15166.5	7891.4	52.0
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	-	25.8	-
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	-	97.7	-
Мебель тавилга үйлдвэрлэл	211.5	328.2	155.2
Бусад үйлдвэрлэл	256.3	94.9	37.0
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	41408.1	59351.4	143.3
ДҮН	376977.1	425079.5	112.8

*-дахин

Хүснэгт 4. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2013 он I-IX сар	2014 он I-IX сар	$\frac{2014}{2013}$ %	үүнээс: экспорт, %
Уул уурхай олборлох үйлдвэр	13227.3	13453.3	101.7	20.3
Төмрийн хүдэр олборлолт	13227.3	10085.1	76.2	16.6
Бусад ашигт малтмал олборлолт	0.0	3368.2	-	3.7
Боловсруулах үйлдвэр	372897.4	435616.9	116.8	0.0
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	231914.0	290711.0	125.4	
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	559.8	727.2	129.9	
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10594.4	11551.5	109.0	
Хүнсний бусад бүтээгдэхүүн	14457.8	69737.2	4.8*	0.4
талх, нарийн боов үйлдвэрлэл	11414.4	11118.8	97.4	
архи үйлдвэрлэл	71010.1	64240.6	90.5	1.0
пиво үйлдвэрлэл	69583.6	72512.0	104.2	
Ундаа үйлдвэрлэл	54293.9	60823.7	112.0	
Нэхмэлийн үйлдвэрлэлт	64189.0	80513.8	125.4	71.1
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	18.4	571.1	31.1*	
Арьс шир боловсруулах үйлдвэр	1601.1	6015.1	3.7*	7.2
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	415.7	463.4	111.5	
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	6850.5	4490.7	65.6	
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	41468.4	29539.3	71.2	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	10609.5	15505.0	146.1	
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	15265.3	6980.2	45.7	
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	0.0	29.5	-	-
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	0.0	97.7	-	-
Мебель тавилга үйлдвэрлэл	209.9	326.4	155.5	
Бусад үйлдвэрлэл	355.6	373.7	105.1	
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	41408.1	59351.4	143.3	
ДҮН	427532.8	508421.6	118.9	11.9

*-дахин



ХҮНСНИЙ БАРААНЫ ҮНЭ

2014 оны 9-р сарын 26-ны өдрийн үнийн ажиглалтаар хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.


Өргөн хэрэглээний хүнсний гол нэрийн зарим бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад “Атар” талх 250 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн дээд гурил 200 төгрөг, 1-р зэргийн гурил 550 төгрөг, 2-р зэргийн гурил 250 төгрөг, элсэн чихэр 150 төгрөг, төмс 500 төгрөг, байцаа, лууван, манжин зэрэг хүнсний ногоо 300 төгрөг, цагаан будаа 350 төгрөг, сүү, тараг 280-300 төгрөгөөр тус тус өссөн байна. Харин хонь, үхрийн махны үнэ өмнөх оны мөн үеэс 200-400 төгрөгөөр буурч, сонгины үнэ тогтвортой байна.

Хүснэгт 5. Хүнсний өргөн хэрэглээний барааны дундаж үнэ*, жил бүрийн 9 сарын байдлаар


№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2013.09	2014.09	$\frac{2014}{2013} \%$
1	Талх “Атар”, “Талх чихэр” ХК	ширхэг	850	1100	129.4
2	Хонины мах, ястай	кг	6900	6500	94.2
3	Үхрийн мах, ястай	кг	8500	8300	97.6
4	Гурил, дээд зэрэг, “Алтан тариа” ХК, савласан	кг	1150	1350	117.4
5	Гурил, 1-р зэрэг, “Алтан тариа” ХК, задгай	кг	700	1250	178.6
6	Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа” ХК, савласан	кг	600	850	141.7
7	Элсэн чихэр	кг	1950	2100	107.7
8	Төмс, монгол	кг	700	1200	171.4
9	Байцаа, монгол	кг	900	1200	133.3
10	Лууван, монгол	кг	1000	1300	130.0
11	Манжин, монгол	кг	1200	1500	125.0
12	Сонгино, хятад	кг	1500	1500	100.0
13	Цагаан будаа	кг	2300	2650	115.2
14	Алим, фүжи	кг	3000	3500	116.7
15	Сүү, задгай	литр	900	1200	133.3
16	Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК	литр	1680	1960	116.7

*- Худалдаа үйлчилгээний “Жаргалант” төв


Зураг 7. Нэг кг махны дундаж үнэ, төгрөг




Зураг 8. Нэг кг гурилын дундаж үнэ, төгрөг



Зураг 9. Нэг кг төмс, лууван, байцааны дундаж үнэ, төгрөг



Зураг 10. Нэг кг манжин, сонгины дундаж үнэ, төгрөг



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2014 оны эхний 9 сард 1168 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 832 хүнээр өссөн байна.


Нийт ажилгүйчүүдийн 55.4 хувь нь эмэгтэйчүүд байна. 2014 оны эхний 9 сард орон тооны цомхотгол 24, байгууллага татан буугдсанаас 18, өөр газраас шилжиж ирсэн 58, сургууль төгссөн 91, цэргээс халагдсан 7, мэргэжлийн ажил олдохгүй 4, цалин багатай 106 болон бусад шалтгаанаар 192 хүн ажилгүй болжээ.

2014 оны эхний 9 сард 314 хүн ажилд орсноос төрийн төсөвт байгууллагад 27, нөхөрлөл компанид 226, улсын үйлдвэрийн газар 3, бусад байгууллагад 58 хүн тус тус ажилд орсон байна.

Хүснэгт 6. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, оны эхний 9 сарын байдлаар

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2012 он	2013 он	2014 он	2012 он	2013 он	2014 он
Нийт ажилгүйчүүд	681	336	1168	100	100	100
Үүнээс: Дээд боловсролтой	221	108	432	32.5	32.1	37.0
Тусгай дунд боловсролтой	34	14	68	5	4.1	5.8
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	34	10	53	2.5	2.9	4.6
Бүрэн дунд боловсролтой	351	176	534	51.5	52.3	45.7
Бүрэн бус дунд боловсролтой	33	20	61	4.8	5.9	5.2
Бага, боловсролгүй	8	8	20	1.2	2.3	1.7

Зураг 11. Ажилгүйчүүд насны бүлгээр, оны эхний 9 сарын байдлаар



Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 40 хувь буюу 467 нь анх удаа ажил хайж байгаа бол 60 хувь буюу 701 нь урьд ямар нэг ажил хийж байжээ.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 16.3 хувь буюу 190 нь 16-24 насны, 36.2 хувь буюу 423 нь 25-34 насны, 23.9 хувь буюу 279 нь 35-44 насны, 23.6 хувь

буюу 276 нь 45-60 насны хүмүүс байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Дүүргийн хэмжээнд 2014 оны эхний 9 сард нийт 952 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 5.5 хувь буюу 55-р, 10000 хүнд эзлэх хувь 7.8 пунктээр тус тус буурчээ.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 17.3 хувийг тэмбүү, 3.9 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 14.6 хувийг салхинцэцэг, 11.6 хувийг гар хөл амны өвчин, 7.7 хувийг трихомониаз, 13.1 хувийг цусан суулга, 1.5 хувийг заг хүйтэн, 4.8 хувийг вируст гепатит, 1.6 хувийг гахайн хавдар өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

Зураг 12. Халдварт өвчнөөр өвчлөгчид



Зураг 13. Төрөлт, нас баралт



Хүснэгт 7. Эх, хүүхдийн эндэгдэл

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	$\frac{2014}{2013} \%$
Амаржсан эхийн тоо	2510	2777	2976	107.1
Амьд төрсөн хүүхэд	2531	2802	3010	107.4
Төрөхийн улмаас эндсэн эх	0	3	3	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	28	38	35	92.1
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	6	6	8	133.3

Төрөхийн улмаас эхийн эндэгдэл өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Харин 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар, 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд өмнө оны мөн үеэс 7.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 8. Дүүрэгт гарсан халдварт өвчин, оны эхний 9 сарын байдлаар


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013 он	2014 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувиар
Халдварт өвчин Үүнээс:	бодит тоо	1007	952	-55	-5.5
	10000 хүнд	81.4	73.6		
Вируст гепатит	бодит тоо	83	46	-37	-44.6
	10000 хүнд	6.71	3.56		
Цусан суулга	бодит тоо	118	125	7	5.9
	10000 хүнд	9.54	9.67		
Улаан эсэргэнэ	бодит тоо	10	13	3	30.0
	10000 хүнд	0.81	1.01		
Сальмонеллөз	бодит тоо	5	4	-1	-20.0
	10000 хүнд	0.40	0.31		
Салхин цэцэг	бодит тоо	211	139	-72	-34.1
	10000 хүнд	17.06	10.75		
Гахайн хавдар	бодит тоо	138	15	-123	-89.1
	10000 хүнд	11.16	1.16		
Ёлом	бодит тоо	4	2	-2	-50.0
	10000 хүнд	0.32	0.15		
Бруцеллөз	бодит тоо	3	1	-2	-66.7
	10000 хүнд	0.24	0.08		
Хоолны хордлого	бодит тоо	10	17	7	70.0
	10000 хүнд	0.81	1.31		
Гар хөл, амны өвчин	Бодит тоо	81	110	29	35.8
	10000 хүнд	6.55	8.51		
Тэмбүү	Бодит тоо	97	165	68	70.1
	10000 хүнд	7.84	12.76		
Заг хүйтэн	Бодит тоо	23	14	-9	-39.1
	10000 хүнд	1.86	1.08		
Трихомониаз	Бодит тоо	37	73	36	97.3
	10000 хүнд	2.99	5.65		
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо	177	211	34	19.2
	10000 хүнд	14.31	16.32		
Бусад	Бодит тоо	4	17	11	2.7 дах
	10000 хүнд	0.24	1.23		



ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд 2014 оны эхний 9 сард 1087 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 20.2 хувиар буюу 183 хэргээр өсчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 58.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.04 пунктээр дээгүүр байна.

Зураг 14. Гэмт хэргийн тоо



Нийт гэмт хэргийн 1.5 хувь буюу 16 нь бусдыг амиа хорлоход хүргэх, 30.6 хувь буюу 333 нь ББМБГУ, 0.8 хувь буюу 9 нь хүчин, 28.3 хувь буюу 308 нь хулгайн хэрэг, 0.9 хувь буюу 10 нь булаалт, 3.5 хувь буюу 38 хэрэг нь дээрэм, 6.3 хувь буюу 68 хэрэг нь залилан мэхлэх гэмт хэрэг, 6.5 хувь буюу 71 хэрэг нь танхайрах, 0.8 хувь буюу 9 нь хүнийг санаатай алах, 8.1 хувь буюу 88 нь ТХХАБАЖЭ, 12.6 хувь буюу 137 нь бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Хүснэгт 9. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр


Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2013.09	2014.09	$\frac{2014}{2013} \%$	Тоо
Бусдыг амиа хорлоход хүргэх	9	16	77.8	7
Хүчин	9	9	0.0	0
Дээрэм	20	38	90.0	18
Хулгай	264	308	16.7	44
Булаалт	8	10	25.0	2
Залилан	37	68	83.8	31
ББМБГУ	282	333	18.1	51
Танхайрах	72	71	-1.4	-1
Хүнийг санаатай алах	11	9	-18.2	-2
ТХХАБАЖЭ	81	88	8.6	7
Бусад	111	137	23.4	26
Бүгд	904	1087	20.2	183

Өмчийн хулгайгаас 282 нь буюу 91.6 хувь нь иргэний өмчийн хулгайн хэрэг, 13 нь буюу 4.2 хувь нь халаасны хулгай, 3 нь буюу 1 хувь нь малын хулгай, 10 нь буюу 3.2 хувь нь авто тээврийн хэрэгслийн хулгай эзэлж байна.

Хүснэгт 10. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор

Хороо	Гэмт хэрэг		Өөрчлөлт		Хүнийг санаатай алах Бусдыг амиа хорлоход хүлгэх					Үүнээс				Булаалт	Дээрэмдэх	Залилан мэхлэх	Танхайрах	ТХХАБАНЖ	Бусад	Илрүүлэлт %
	2013.I-IX сар	2014.I-IX сар	Тоо	%						ИӨХ	Малын хулгай	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай							
1	69	60	-9	-13.0	0	0	12	0	13	10	0	0	2	0	9	4	4	6	12	53.0
2	77	129	52	67.5	0	1	40	0	30	25	0	1	2	1	9	12	7	9	20	48.4
3	108	133	25	23.1	0	3	41	3	30	28	0	0	0	0	0	9	6	10	31	63.2
4	62	84	22	35.5	0	2	18	0	31	27	2	1	1	3	2	4	8	8	8	50.0
5	24	34	10	41.7	0	0	12	0	6	6	0	0	0	0	2	1	7	6	0	80.0
6	34	26	-8	-23.5	0	1	9	0	5	5	0	0	0	0	2	1	2	5	1	100
7	25	26	1	4.0	0	1	11	0	5	4	0	0	1	0	0	0	3	5	1	70.0
8	60	45	-15	-25.0	2	1	16	0	14	14	0	0	0	0	0	1	4	5	2	56.0
9	58	56	-2	-3.4	4	1	18	1	11	11	0	0	0	0	1	1	7	4	8	75.0
10	55	69	14	25.5	0	0	19	0	22	20	2	0	0	0	0	4	8	6	10	46.1
11	114	155	41	36.0	1	3	49	1	49	44	0	0	1	1	3	15	4	9	20	60.8
12	29	41	12	41.4	2	0	13	1	22	18	3	0	0	0	0	0	0	1	2	60.8
13	28	19	-9	-32.1	0	2	7	1	5	5	0	0	0	0	0	0	1	2	1	100
14	30	33	3	10.0	0	0	6	0	22	15	5	1	0	0	0	0	2	1	2	45.8
15	104	137	33	31.7	0	1	51	1	27	22	0	1	2	5	8	16	4	6	18	69.2
16	27	40	13	48.1	0	0	11	1	16	15	1	0	0	0	2	0	4	5	1	54.5
Дүн	904	1087	183	20.2	9	16	333	9	308	269	13	4	9	10	38	68	71	88	137	58.9

Зураг 15. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор



ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ 2014 оны эхний 9 сард 38713 өргөдөл, гомдол ирснээс 37948-ыг хуулинд заасан хугацаанд бүрэн шийдвэрлэж, 339 нь хүлээгдэж байгаа, 370 нь хугацаа болоогүй, 21 нь хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол байна.

Хүснэгт 11. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Д/д	Өргөдөл, гомдлын агуулга	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга				Бусад байгууллагад шилжүүлсэн	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хүлээгдэж байгаа	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
			Амаар	Бичгээр	Утсаар	Цахим сүлжээгээр	Гомдол	Санал	Мэдэгдэл	Хүсэлт					
1	ЗХХ	310	45	23		242	13	2	-	295	8	229		69	4
2	СТСХ	10		-	-	10	-	-	-	10	-	4	-	5	1
3	ЭЗТХ	35	6	-	-	29	1	4	-	30	-	25	-	10	-
4	НХ	150	51	65	17	17	-	-	-	150	-	148	-	2	-
5	ДБТХ	198	-	-	-	198	180	-	-	18	-	163	-	34	1
6	ХҮХ	728	297	342	65	24	28	8	-	692	65	652	1	9	1
ЗДТГ-ын дүн		1431	399	430	82	520	222	14	0	1195	73	1221	1	129	7
1	ХХ	720	241	357	119	3	2	-	311	407	268	363	10	79	-
2	НХҮХ	31048	-	31043	-	5	-	-	-	31048	-	31043	5	-	-
3	ӨГХА	5319	520	4897	-	422	-	-	520	5319	-	4820	323	162	14
4	БүХ	40	-	3	-	54	35	-	-	22	-	57	-	-	-
5	БоХ	104	2	102		-	-	1	-	103	-	104	-	-	-
6	ОБХ	34	-	34	-	-	-	-	-	34	3	34	-	-	-
Дүүргийн дүн		38713	1162	36866	201	1004	259	15	831	38128	344	37948	339	370	21

Танилцуулгыг эрхлэн гаргасан: мэргэжилтэн Э.Батзаяа

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

И-мэйл: han-uul@nso.mn
Веб: www.nso.mn
www.1212.mn
www.ubstat.mn



Статистикийн сар бүрийн
танилцуул гыг эндээс татаж авна уу.